

БАТЛАВ
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Л.МӨНХЗУЛ



2025 оны 1.0 сарын 24-ний өдөр

Улаанбаатар хот

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ЯВЦЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН ДААЛГАВАР

Ажлын зорилго: Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтэд явцын дүн шинжилгээ хийх, үр дүнд суурилсан санал, зөвлөмж боловсруулахад оршино.

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА:

Эхлэх хугацаа: 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр

Дуусах хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 20-ны өдөр

НЭГ.ҮНДЭСЛЭЛ

Үндэсний статистикийн хорооны 2024 оны жилийн эцсийн мэдээгээр Монгол Улсын нийт хүн ам 3.5 саяд хүрч, үүнээс 18 хүртэлх насны хүүхэд 37.1 хувийг эзэлж байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн /Шинэчилсэн найруулга/ 2024 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн бөгөөд уг хуулийн шинэчлэлээр хүүхэд хамгааллын үйлчилгээ, хүүхэд хамгааллын тогтолцоог өргөжүүлсэн. Тухайбал, уг хуулийн Хоёрдугаар бүлэгт Хүүхэд хамгааллын үйлчилгээний хэлбэр, кейс менежментийн үе шатыг, Гуравдугаар бүлэгт Гэр бүл, нийгмийн орчин дахь хүүхэд хамгаалал, хуулийн Дөрөвдүгээр бүлэгт Хүүхэд хамгааллын тогтолцоо, удирдлага, зохион байгуулалт, Тавдугаар бүлэгт Хүүхэд хамгааллын санхүүжилт ба хяналтын зохицуулалтыг тус тус хуульчилсан.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийг хэрэгжүүлэхэд хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөрийн зардалд 20,6 тэрбум төгрөг батлагдсанаас 2025 оны төсвийн тодотголоор 20,5 тэрбум төгрөг батлагдсанаас, 2025 оны 8 дугаар сарын байдлаар /өссөн дүнгээр/ төсвийн гүйцэтгэл 51.4 хувьтай байна.

2025 онд хүүхэд хамгааллын кейс шийдвэрлэлтийг 75 хувьд, хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйлчилгээг нийт хүүхдийн 70 хувьд хүргэх зорилттой ажиллаж байна.

Иймд Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтэд явцын дүн шинжилгээ хийж, хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар, үр дүнг дээшлүүлэх зорилгоор уг удирдамжийг боловсрууллаа.

ХОЁР. АЖЛЫН ЦАР ХҮРЭЭ

Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтэд явцын дүн шинжилгээ хийж, нөхцөл байдал ба тулгамдсан асуудлыг тодорхойлж, 2026 онд хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, хүүхэд хамгааллын чанар үр дүнг дээшлүүлэх санал, зөвлөмж боловсруулах ажлыг гүйцэтгэнэ.

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ

Ажлын даалгаварт тусгагдсан ажлын тоо, төсөл, арга хэмжээ бүрээр дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

№	Гүйцэтгэх ажил	Агуулга	Хугацаа	Төсөв (мян.төг)
1.	Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Төсвийн ерөнхийлөн захирагчийн аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан 2025 оны гэрээний хэрэгжилтийн тайланд дүн шинжилгээ хийх	Аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан 2025 оны гэрээний хэрэгжилтийн тайланг авч, дүн шинжилгээ хийх	XI/03-07	19,800,000
2.	Хүүхэд хамгааллын тухай хуулийн хоёрдугаар бүлгийн хэрэгжилтэд явцын дүн шинжилгээ хийх	- Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар, аймаг, дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, хэлтсийн 2025 оны хүүхэд хамгааллын үйлчилгээний хэрэгжилт, санхүүгийн тайлан, статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийх; 2 аймаг, 4 сум, 6 хороог түүвэрлэж Хамтарсан баг, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, хүүхэд хамгаалал, гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн, хүүхэд, эцэг, эхийн төлөөлөлтэй ярилцлага зохион байгуулах;(танхим, цахим) - Хүүхэд, гэр бүлтэй ажилладаг төрийн бус байгууллагатай уулзалт хийх; (танхим, цахим) - Төрийн болон төрийн бус байгууллагын дэргэдэх түр хамгаалах байрны үйл ажиллагаатай танилцах.	XI/07- XI/14	
3.	Хүүхэд хамгааллын тухай хуулийн дөрөв, тавдугаар бүлгийн хэрэгжилтэд явцын дүн шинжилгээ хийх	2 аймаг, 4 сум, 2 дүүрэг, 4 хороог түүвэрлэж Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, Засаг дарга, Хүүхдийн төлөө зөвлөлийн гишүүн, Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүн, Хамтарсан багийн гишүүн, хүүхдийн эрхийн	XI/17-21	

		улсын байцаагчтай уулзалт, ярилцлага зохион байгуулах; (танхим) • Үйл ажиллагааны тайланд дүн шинжилгээ хийх.		
4.	Дүн шинжилгээний явцын тайлан ирүүлэх	• Дүн шинжилгээний явцын тайланг Ажлын хэсэгт танилцуулж, санал зөвлөмж авах (танхим)	XI/28	800,000
5.	Дүн шинжилгээний тайлан, зөвлөмж танилцуулах	• Дүн шинжилгээнд оролцогчдод тайланг танилцуулах (танхим, цахим)	XII/04	1,200,000
6.	Дүн шинжилгээний тайлан, зөвлөмжийг Сайдын зөвлөлд танилцуулах	• Дүн шинжилгээний тайлан, танилцуулгыг урьдчилан ирүүлсэн байх • Тайланд Сайдын зөвлөлөөс өгсөн санал, зөвлөмжийг тусган сайжруулах (танхим)	XII/08	400,000
7.	Эцсийн тайлан ирүүлэх	Тайлан, зөвлөмжийг утга найруулга, үг, үсгийн алдаагүй боловсруулах.	XII/20	

ДӨРӨВ.ГҮЙЦЭТГЭГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Гүйцэтгэгч нь баг, хувь хүн байж болно.

Туршлага:	Ур чадвар:
- Хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж байсан туршлагатай; - Баримт бичгийн судалгаа хийх, гарын авлага, материал боловсруулж байсан туршлагатай; - Хүүхэд, гэр бүлийн чиглэлээр ажилласан туршлагатай; - Захиалагч талын хэрэгцээ, шаардлагад нийцсэн тайлан, зөвлөмж, танилцуулгыг заасан хугацаанд бэлтгэн нийлүүлэх чадавхтай байх.	- Мэдээлэл цуглуулах, шинжлэх, боловсруулах чадвартай; - Дүн шинжилгээ хийх аргачлал боловсруулах, баримт бичиг, тайлан, илтгэл бэлтгэх, илтгэх чадвартай; - Уулзалт, хэлэлцүүлэг чиглүүлэх, зохион байгуулах чадвартай. - Бусдыг хүндлэх, харилцах, зөвлөн туслах ур чадвартай; - Багаар ажиллах ур чадвартай байх.

ТАВ.ХЯНАЛТ, ТАЙЛАГНАЛТ

Тус яамны Гэр бүлийн бодлогын газар, холбогдох мэргэжилтэн, Ажлын хэсэг үйл ажиллагаанд хяналт тавина.

ЗУРГАА.САНХҮҮЖИЛТ, ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

Хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлнэ. Арга хэмжээний төлбөр нь 19,800,000 /арван есөн сая найман зуун мянга/ төгрөг байна.

Явцын тайлан ирүүлснээр төлбөрийн 60 хувийг, эцсийн тайланг хүлээлгэн өгсний дараа, хянаж үлдэгдэл төлбөрийг төлнө.

Төлбөрийг Монгол төгрөгөөр олгох бөгөөд төлбөрт бүх зардал, татвар, хураамж багтсан болно.

ДОЛОО.БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

- Ажил гүйцэтгэгчийн анкет, (баг бол багийн гишүүн бүр);
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Диплом болон холбогдох гэрчилгээний хуулбар;
- Туршлагыг нотлох сургалт арга хэмжээний танилцуулга;
- Албан хүсэлт;
- Ур чадварыг үнэлэх нэмэлт баримт бичиг.

---oOo---

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ЯВЦЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН ДААЛГАВАР

Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтэд явцын дүн шинжилгээ хийж, нөхцөл байдал ба тулгамдсан асуудлыг тодорхойлж, 2026 онд хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, хүүхэд хамгааллын чанар үр дүнг дээшлүүлэх санал, зөвлөмж боловсруулах ажил гүйцэтгэх баг, иргэнийг сонгон шалгаруулалтад оролцохыг урьж байна.

ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Ижил төстэй 3-аас доошгүй ажил үйлчилгээг амжилттай гүйцэтгэсэн туршлагатай;
- Хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж байсан туршлагатай;
- Баримт бичгийн судалгаа хийх, гарын авлага, материал боловсруулж байсан туршлагатай;
- Хүүхэд, гэр бүлийн чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай;
- Мэдээлэл цуглуулах, шинжлэх, боловсруулах чадвартай;
- Дүн шинжилгээ хийх аргачлал боловсруулах, баримт бичиг, тайлан, илтгэл бэлтгэх, илтгэх чадвартай;
- Уулзалт, хэлэлцүүлэг чиглүүлэх, зохион байгуулах чадвартай.
- Бусдыг хүндлэх, харилцах, зөвлөн туслах ур чадвартай;
- Багаар ажиллах ур чадвартай байх.
- Захиалагч талын хэрэгцээ, шаардлагад нийцсэн тайлан, зөвлөмж, танилцуулгыг заасан хугацаанд бэлтгэн нийлүүлэх чадавхтай байх.

БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

- Ажил гүйцэтгэгчийн анкет, (баг бол багийн гишүүн бүр);
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Диплом болон холбогдох гэрчилгээний хуулбар;
- Туршлагыг нотлох сургалт арга хэмжээний танилцуулга;
- Албан хүсэлт;
- Ур чадварыг үнэлэх нэмэлт баримт бичиг.

Материал хүлээн авах хугацаа 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 17:00 цаг хүртэл gereltod@mflsp.gov.mn цахим шуудангаар, эсхүл Чингэлтэй дүүрэг, Нэгдсэн Үндэстний гудамж-5, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны байранд цаасаар ирүүлнэ үү.